



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

“Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-д
банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын
үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1. Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.13, 4.2, 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт бүртгүүлэхийг “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК /Н.Ундрах/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГЭЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

